



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Мон сант алдар” ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 5.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолын 1.2, 1.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон сант алдар” ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгосугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зөвшөөрлийн талаарх тэмдэглэгээг 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хийлгэхийг “Мон сант алдар” ХЗХ /М.Батмөнх/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000572